



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.02 № 01/704
танай _____ -ны № _____ -т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Даваадоржийн Лхагвасүрэнгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор бие даан нэр дэвшигч Даваадоржийн Лхагвасүрэнгийн ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Даваадоржийн Лхагвасүрэнгийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (2.. хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Даваадоржийн Лхагвасүрэнд.

Хувийг: Хөвсгөл аймгийн Сонгуулийн хороонд.

Хавсралт 2.. хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬ-2024

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ДАВААДОРЖИЙН
ЛХАГВАСҮРЭНГИЙН
ДЭВШҮҮЛЖ БУЙ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2024.07.24.



0000000001 *З. Дэг*

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ДАВААДОРЖ ОВОГТОЙ ЛХАГВАСҮРЭНГИЙН
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2024.07.24

Мөрөн хот

Нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөрийг боловсруулахдаа УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, мөн 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, 2001 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2015 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Хөвсгөл аймгийн нийгэм, эдийн засгийг 2016-2030 онд хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр” зэрэг баримт бичгүүдэд дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд тулгуурлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль болон мөн хуулийн 37 дугаар зүйлийн хэсэгт нийцүүлэн боловсрууллаа.

“Иргэдийн амьдралыг сайжруулах”-д мөрийн хөтөлбөрийн зорилго оршино. Дээрх зорилгын хэрэгжүүлэхээр дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ.

1. Нутгийн өөрөө удирдах байгууллагыг чадавхжуулах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

2. Нийгмийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хувь хүн, гэр бүлийн хөгжлийг бүрэн дэмжсэн байх зарчимд тулгуурласан бодлого хэрэгжүүлнэ.

3. Бүсчлэн хөгжүүлэх Нэг аймаг нэг салбар, нэг сум нэг бүтээгдэхүүнийг брэнд болгож хөгжүүлэхэд анхаарна.

4. Мөрөн хотын утаа, хогны менежментийг сайжруулах бодлого хэрэгжүүлнэ

5. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх бодлого баримтална.

6. Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах бодлого баримтална.

7. Ажлын байр нэмэгдүүлсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ажил олгосон аж ахуйн нэгж болон ажлын байрандаа олон жил тогтвор суурьшилтай ажилласан иргэдийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөр санаачилна.

8. Иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг ажлын байртай шууд холбон тогтвортой ажил, хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгох бодлого баримталж ажиллана.

БОЛОВСРУУЛСАН:



Д.ЛХАГВАСҮРЭН

/БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ/
Хаяг: Хөвсгөл аймаг, Мөрөн
сум, 11-р баг 96-12 тоот
Регистрийн дугаар:
РЮ84092670
Холбоо барих: 96191717
Мэйл:
Lhagvaa8888@gmail.com

0000000002

